



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2020 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 178

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Авлигатай тэмцэх газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 270,000,000.00 (хоёр зуун далан сая) төгрөгийн балансын үнэ, 60,000,000.00 (жаран сая) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан автомашиныг Онцгой байдлын ерөнхий газарт балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй

2. Авлигатай тэмцэх газрын Тамгын хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар 3.Баасанням, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Т.Бадрал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. “Ди Би Эм Лизинг” ХХК-тай санхүүгийн түрээсийн гэрээ байгуулж, гэрээний хугацаа дуусмагц автомашины улсын дугаарыг шилжүүлэн авах, арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НАРАНГЭРЭЛ

900261



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн  
178 дугаар тогтоолын хавсралт

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРААС ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАРТ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ  
АВТОМАШИН

| Д/д      | Автомашины марк, улсын<br>дугаар, арал           | Үйлдвэрлэсэн,<br>ашиглалтад<br>орсон он | Балансын үнэ              | Хуримтлагдсан       | Үлдэгдэл өртөг           |
|----------|--------------------------------------------------|-----------------------------------------|---------------------------|---------------------|--------------------------|
|          |                                                  |                                         |                           | элэгдэл<br>(төгрөг) |                          |
| 1        | Хьюндай Юниверс, 40-51 УНЗ,<br>KMJKG18TRHC914715 | 2016/2016                               | 270,000,000.00            | 60,000,000.00       | 210,000,000.00           |
| Нийт дүн |                                                  |                                         | 270,000,000.00            | 60,000,000.00       | 210,000,000.00           |
|          |                                                  |                                         | (хоёр зуун далан сая<br>) | (жаран сая)         | (хоёр зуун<br>арван сая) |